

УСНЫ КОМПАКТ

2024 оны онцлох:

Монголын Мянганы сорилтын сангийн Гүйцэтгэх захирал

Э.Энхгэрэл: Усны Компакт бол сүүлийн 30 жилд усны салбарт оруулж буй хамгийн том хөрөнгө оруулалт

Манай улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн төв болсон Улаанбаатар хот цаашдаа ус хангамжийн асуудалд санаа зоволгүйгээр дараа дараагийнхаа төвлөрлийн бүс, дагалдах дэд бүтцийг төлөвлөөд, хөгжлийн чиг хандлага, бодлого төлөвлөлтдөө нийцүүлэн усны нөөцөө зохицуулаад явах боломжийг бүрдүүлж байна. Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөр нь сүүлийн 30 жилд усны салбарт оруулж буй хамгийн том хөрөнгө оруулалт юм.

Монгол Улсын гуравдагч хөршийн бодлого, Монгол-Америкийн стратегийн түншлэлийн бодит илэрхийлэл болсон Усны Компакт гэрээг хугацаанд нь, амжилттай хэрэгжүүлэхэд оролцогч талууд нягт хамтран ажиллаж, 2024 онд чамгүй амжилт гаргаад байна. Монгол Улсын Засгийн газар Компакт гэрээгээр хүлээсэн үүргээ мөн амжилттай биелүүлж байна.



Эх сурвалж: Eagle TV

Үргэлжлэл 5-р нүүрт



Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийг 2025 оны хоёрдугаар улирлаас туршилтаар ажиллуулна

Үндэсний компаниуд маань энэ төсөл дээр ажилласнаар олон улсын түвшинд мега төсөл хэрэгжүүлэх чадавх, бяд бүрэлдэж байна

Жил бүр газрын гүнд нь үлдээж байгаа 18 сая шоо метр ус "эко системийн үйлчилгээ"-ний хувьд Туул голын сав газарт маш чухал нөлөөтэй



Монголын Мянганы сорилтын сангийн Дотоод аудитын газрын захирал

Б.Батбаяр: Монголын Мянганы сорилтын сангийн бүх үйл ажиллагааны тоглоомын дүрэм тодорхой, ойлгомжтой учир авлигаас ангид байдаг

Монголын Мянганы сорилтын сан (МСС) нь Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 297 дугаар тогтоолоор байгуулагдсан Төрийн өмчит үйлдвэрийн газар. Гол чиг үүрэг нь Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Мянганы сорилтын корпорац (МСК) хооронд байгуулсан хоёр дахь Компакт гэрээний хүрээнд Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх томоохон цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг Засгийн газрыг төлөөлөн зохион байгуулах юм. Манай байгууллага анхнаасаа авлигыг үл тэвчих, ил тод, ёс зүйтэй, хариуцлагатай байх соёлыг хэвшүүлэхийг зорьж ажилласан.

Үргэлжлэл 5-р нүүрт

ТӨСӨЛ 1. УС ХАНГАМЖИЙН БАРУУН ЭХ ҮҮСВЭРИЙГ ШИНЭЭР БАЙГУУЛАХ ТӨСӨЛ

Төслийн хүрээнд Биокомбинат, Шувуун фабрик орчмын газрын доорх усны ордыг түшиглэн ундны усны хоёр шинэ эх үүсвэр, ус дамжуулах шугам хоолой, дэвшилтэт технологи бүхий Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийг байгуулна. Төсөл хэрэгжсэнээр Улаанбаатар хотын ус хангамж жилд 50 сая орчим куб метрээр нэмэгдэх юм.



2024 оны онцлох:

Ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн захирал

Б.Батсүх: Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийг 2025 оны хоёрдугаар улирлаас туршилтаар ажиллуулна

Улаанбаатар хотын Ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийг бид барилга угсралтын хоёр багцаар хийж гүйцэтгэж байна. Нийт 30 худаг гаргах, Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн байгууламж барих, дээр нь 55 км шугам хоолой барих зэрэг ажил хийж байна. 2024 онд Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн барилга, угсралтыг 90 хувьд хүргэхээр төлөвлөсөн бол жилийн эцсийн байдлаар бид 93 хувьд хүргэж давуулан биелүүлсэн ололттой байлаа. Хоёр дахь онцлог гол ажил бол гадна цахилгаан хангамжийн барилга угсралтын ажлыг 2024 онд улсын төсвөөр Эрчим хүчний яамны захиалгаар бүрэн хийж, цаг хугацаанд нь ашиглалтад оруулсан нь бас төсөлтэй холбоотой том амжилт байлаа. Мэдээж, төслийг хэрэгжүүлэх явцад маш олон хүндрэл, бэрхшээл учирсны нэг нь энэ оны 6-7 дугаар сард болсон үер байлаа. Энэ үертэй холбоотойгоор 3 сар гаруй хугацаанд Биокомбинатын талбайд барилга угсралтын ажил бүрэн зогссон. Бид 2024 оны 10 дугаар сарын эхээр барилга угсралтын ажлаа хэвийн үргэлжлүүлэх бололцоотой болсон. Шугам хоолойн барилга угсралтын ажлын хүрээнд гол доогуур болон төмөр зам доогуур өрөмдлөг, сүвлэгээний ажлууд хийнэ. Энэ бол манай улсад өмнө нь хийж байгаагүй шинэ ажил, цоо шинэ туршлага.



Эх сурвалж: eagle.mn

Цооногийн өрөмдлөгийн ажлыг бүрэн дуусгав

“Баран групп”-ийн нийт ажлын гүйцэтгэл 2024 оны эцсийн байдлаар 68.38%-тай байна. Цооногийн өрөмдлөгийн ажлыг туслан гүйцэтгэгч “Эрдэнэдриллин” ХХК 2024 онд бүрэн хийж гүйцэтгэв. Биокомбинатын эх үүсвэрийн гүний худгийн барилгын ажил 43%, Шувуун фабрикийн эх үүсвэрийн гүний худгийн барилгын ажил 37.5% бол дамжуулах шугам хоолойн болон хаалтын худгийн ажил 93.1%, төслийн нийт сүвлэгээний ажил 43.66%-тай явж байна.

Түүхий ус дамжуулах хос шугам суурилуулах ажил 100 хувьд хүрлээ

“МАПА Иншаат ве Тижарет” компани нэмэлт ажлын хүрээнд нийт 13,155 м ус дамжуулах шугам хоолойн угсралтын ажлыг гүйцэтгэж, нийт гүйцэтгэл 79.56%-д хүрлээ. Харин түүхий ус дамжуулах хос шугамын угсралтын ажлын гүйцэтгэл 100%-д хүрч, Биокомбинатын цуглуулах шугамын ажлын гүйцэтгэл 72.53%, Цэвэр ус дамжуулах шугамын ажлын гүйцэтгэл 85.05%-тай үргэлжилж байна.

Гүний худгийн насосуудаа хүлээн авав

Биокомбинат, Шувуун фабрикийн шинэ эх үүсвэрийн 30 гүний худагт суурилуулахаар Польшийн “Ловара” компанид үйлдвэрлэсэн насосуудыг төслийн талбайд хүлээн авлаа. Насоуд нь 72-74 литр/сек-ийн хүчин чадалтай. Монгол Улсдаа хамгийн өндөр хүчин чадалтай тооцогдох уг насос усаа 30-70 метрийн гүнээс татах юм. Насосыг ирэх тавдугаар сараас шат дараатайгаар суурилуулж эхэлнэ.

Ус гүн цэвэршүүлэх урвуу осмосын мембранаа хүлээн авлаа



Урвуу осмосын мембран нь хүний үснээс 500,000 дахин нарийн зайгаар усыг шүүдэг

Ус хангамжийн Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн хүрээнд байгуулж буй Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрт ашиглах урвуу осмосын мембраныг төслийн гүйцэтгэгчид 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр хүлээн авлаа.

Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр хоёр дамжлагат технологитой. Эхнийх нь Уламжлалт технологи буюу агааржуулалт, коагуляц, флокуляц, шүүлтүүр бол хоёр дахь буюу дэвшилтэт технологи нь усыг хамгийн нарийн түвшинд урвуу осмосын аргаар шүүнэ. Урвуу осмосын арга буюу орчин үеийн дэвшилтэт энэ аргыг Монголд ундны ус цэвэршүүлэхэд анх удаа нэвтрүүлж буйгаараа онцлог юм. Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн бүтээн байгуулалт, хяналт удирдлагын СКАДА системийг суурилуулалтын ажил 93.30 хувьтай байна.

Тоон мэдээлэл

98.77% Ус гүн цэвэршүүлэх байгууламжийн барилга

Цэвэршүүлсэн усны сан болон насос станцын барилга 98.91%

96.82% Тунадас боловсруулах байгууламжийн барилга

Цахилгаан/генераторын барилга угсралтын ажил 99.55%

73.25% Урвуу осмосын байгууламжийн барилга угсралтын ажил

ТӨСӨЛ 2. ХАЯГДАЛ УС ДАХИН БОЛОВСРУУЛАХ ТӨСӨЛ

Төслийн хүрээнд шинэ Төв цэвэрлэх байгууламжийн дэргэд Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр (“ХУДБҮ”) болон дахин боловсруулсан усыг “ДЦС-3”, “ДЦС-4” ТӨХК-ууд руу дамжуулах системийг барьж байгуулна. Төсөл хэрэгжснээр дулааны цахилгаан станцуудын техникийн усны хэрэглээний 85 хүртэл хувийг дахин боловсруулсан усаар орлуулж, гүний цэвэр усны хэрэглээг жилд 18.0 сая хүртэл куб метрээр бууруулах юм.

2024 оны онцлох:

Хаягдал ус дахин боловсруулах төслийн захирал

Д.Мэндсайхан: Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн барилга угсралтын ажил 69 хувьтай байна

Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн барилга угсралтын ажил 69 хувьтай, харин тус үйлдвэрээс ДЦС-ууд хүртэл ус дамжуулах шугам хоолойн угсралт суурилуулалт, ДЦС-уудын усны схемийн өөрчлөлтийн ажил 68 хувьтай үргэлжилж байна. Одоогийн байдлаар ХУДБҮ-ээс ДЦС-4 хүртэлх 1000 мм-ийн голчтой 4,6 км уян ширмэн хоолойн барилга угсралтын ажлыг бүрэн гүйцэтгэж дууссан. Ингэхдээ Сонсголонгийн авто замын доогуур сүвлэж шугам хоолой суурилуулах ажлыг Монголд анх удаа замын хөдөлгөөнийг зогсоохгүйгээр хийж гүйцэтгэсэн. Мөн ДЦС-3-ын дунд даралтын насосуудыг суурилуулж, эргэлтийн болон техникийн усны насосуудыг ашиглалтад хүлээн авсан амжилттайгаар 2024 оныг үдэж байна. Дулааны цахилгаан станцын баруун талд хуримтлагдсан барилгын 10 мянган тонн хур хогийг мөн цэвэрлэлээ. 2024 онд ус бороо ихтэй, хөрсний ус дээшилсэн, мөн газар чөлөөлөлт болон нүүлгэн шилжүүлэлтэй холбоотой тулгамдсан асуудлуудыг шийдэж ажиллалаа.



Дахин боловсруулсан ус ашиглахтай холбоотой хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхаарч ажиллахаа илэрхийлэв

Улсын Их Хурлын даргын 2024 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 79 дүгээр захирамжаар байгуулагдсан Ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах эрхийн хэрэгжилтийг үнэлж, санал, дүгнэлт гаргах, цаашид авах арга хэмжээний санал боловсруулан танилцуулах үүрэг бүхий УИХ-ын Ажлын хэсгийн ахлагч Б.Уянга, тус ажлын хэсгийн гишүүн Ж.Золжаргал, Э.Болормаа, М.Ганхүлэг нар Усны Компакт гэрээний хүрээнд барьж байгуулж буй Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр болон Хаягдал ус дахин

боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажилтай танилцлаа. Ажлын хэсгийн гишүүд нийслэлчүүдийн ойрын 30 жилийн ус хангамжийг баталгаажуулах Усны Компактын төслүүдийг цаг хугацаанд нь амжилттай хэрэгжүүлэх, тэр дундаа дахин боловсруулсан усны хэрэглээг Монгол Улсад өргөн хүрээнд, эрчим хүчний салбарт анх удаа нэвтрүүлэхэд шаардлагатай хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхаарч, дэмжлэг үзүүлэн ажиллахаа илэрхийллээ.

Сурвалжилга

Монголын хамгийн анхны, хамгийн том ХАЯГДАЛ УС дахин боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалттай танилцлаа

...Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр ашиглалтад орсноор ДЦС-уудын техникийн усны хэрэглээний 80 хувийг дахин боловсруулсан усаар орлуулж, гүний цэвэр усны хэрэглээг жилд 18 сая хүртэл шоо метрээр бууруулна.

... Хэдийнэ өвлийн улирал эхэлж, барилгын улирал дуусаж байгаа ч манай сурвалжлах багийг Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын талбайд ирэхэд түм түжигнэж, бум бужигнасан хөдөлгөөнтэй, бүтээн байгуулалт ид өрнөж байв. Усны салбарт шинэ стандарт, шинэ жишиг, шинэ үйлдвэр нэвтрэх цаг ойртсоор...



Эх сурвалж: itoin.mn

Хаягдал ус дахин боловсруулах төслийн мэргэжилтэн, инженер

Б.Билгүүн: Ирэх жилийн барилгын улирал эхлэхэд одооноос төлөвлөж, бэлдэж байна



Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр ашиглалтад ороход хамгийн гол шаардлага бол шинэ Төв цэвэрлэх байгууламжаас MNS 4943:2015 стандарттай ус хүлээн авах ёстой. Энэ стандартад нийцсэн усыг манай үйлдвэрт нийлүүлэхийн тулд Шинэ ТЦБ нь өөрөө MNS 6561 гэсэн стандартыг хангасан ус хүлээж авах ёстой. Одоогоор үйлдвэрүүдээс гарч байгаа хаягдал ус MNS 6561 стандартыг хангахгүй байгаа учраас Төв цэвэрлэх байгууламжид ирж байгаа ус их хэмжээний бохирдолтой байна. Тиймээс энэ бохирдлыг бууруулж, шинэ ТЦБ-ыг ч, манай Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийг ч хэвийн ажиллах боломжоор хангах зорилгоор 2021 оны 3 дугаар сард ЗГ-ын 53 дугаар тогтоолоор “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-г баталсан.

ТӨСӨЛ 3. УСНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨСӨЛ

Усны салбарын хууль эрх зүйн орчин, бодлого зохицуулалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлж, салбар байгууллагуудын чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн 5 дэд үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Л.Өнөржаргал: Усны салбарын тогтвортой байдлыг хангах төсөл Компактын хөтөлбөрийнхөө үр өгөөжийг урт хугацаанд хадгалахад чиглэсэн

...Усны салбарын тогтвортой байдлыг хангах төсөл нь Ус хангамжийн Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах болон Хаягдал ус дахин боловсруулах төслийн хүрээнд бүтээн байгуулж буй томоохон дэд бүтцийнхээ тогтвортой байдлыг хангах, нийт Компактын хөтөлбөрийнхөө үр өгөөжийг урт хугацаанд хадгалахад чиглэсэн 5 дэд үйл ажиллагааг хэрэгжүүлж буй чухал төсөл.

Энэ төслийн хүрээнд таван дэд үйл ажиллагаа, 30 гаруй жижиг төсөл хэрэгжүүлж, байгаль орчны, нийгмийн, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад салбарын байгууллагуудад

дэмжлэг үзүүлж байна. Жишээ нь, манай хоёрдугаар дэд үйл ажиллагааны хүрээнд бид Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газрын шугамд холбогдсон 180 ус түгээх байрыг бүрэн автоматжуулж байгаа. УСУГ өөрийн хөрөнгөөр 2015-2016 онд 150 ус түгээх байрыг автомат болгосон байдаг. Одоо нийтдээ шугамд холбогдсон 330 гаруй автомат худагтай боллоо гэсэн үг. Ус түгээх байр руу ус хүргэхэд нэлээд өндөр зардал гардаг. УСУГ-ын мэдээлснээр 1 литр усыг хүргэхэд 19 төгрөгийн зардал гарч байгаа ч хэрэглэгчдэд 2 төгрөгөөр борлуулдаг.



Эх сурвалж: Eagle TV

2024 оны онцлох:

Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн захирал

Л.Өнөржаргал: Төслийн нийт гүйцэтгэл 78%-д хүрээд байна



2024 онд Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн хүрээнд гэрээт зөвлөхүүд болон баг, хамт олонтойгоо хамтран олон чухал ажлыг хийж хэрэгжүүллээ. Үндэсний статистикийн хороотой хамтран Өрхийн ус худалдан авах чадварын судалгааг Монгол Улсад олон улсын аргачлалаар анх удаа хийж гүйцэтгэн, оролцогч талууддаа хүргэлээ.

Нидерландын ус ашиглалтын байгууллагуудын туршлагаас судлах сургалтын аяллыг тус улсад 5 удаа зохион байгуулж, Ус сувгийн 90 орчим инженер, техникийн ажилтнуудыг сургалтад хамруулаад байна.

Үйлдвэр, аж ахуйн газрууд хаягдал усаа хэрхэн цэвэрлэх талаар иж бүрэн гарын авлагыг 16 цуврал вэбинар буюу цахим сургалтын материалын хамт боловсруулж, 1000 орчим аж ахуйн нэгж, байгууллагад хүргэж ажиллалаа.


Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хүрээнд төрөөс үзүүлэх бүх үйлчилгээг цахимаар авах нөхцөлийг бүрдүүлсэн Усны мэдээллийн ewater.mn нэгдсэн системийг хөгжүүлж, Усны газарт хүлээлгэж өглөө. Улс орон даяар ус ашиглах, хаягдал ус татан зайлуулахтай холбоотой бүхий л дүгнэлт, зөвшөөрлийг энэхүү системээр хүлээн авч шийдвэрлэж эхлээд байна.

Нийслэлийн 6 дүүргийн гэр хорооллын шугамд холбогдсон 180 ус түгээх байрыг автоматжуулж, 24 цагийн ажиллагаанд шилжүүлэх ажлын хэрэгжилт 98 хувьд хүрээд байна.

Нидерландын ээлжит сургалтад 18 инженер, техникийн ажилтан хамрагдлаа



Нидерланд улсын ус ашиглалтын байгууллагуудын ментор, экспертүүдтэй мэдлэг туршлага солилцох тав дахь сургалтын аялал 2024 оны 12 дугаар сарын 11-23-нд болж, УСУГ-ын 18 инженер, техникийн ажилтан хамрагдлаа. Сургалтад оролцогчид Орлого болоогүй ус (Техникийн аргачлалууд), Гидравлик загварчлал (WaterGEMS болон EPANET программ хангамж), Эрсдэлд суурилсан хөрөнгийн менежмент (Markit болон PRP загварчлал) гэсэн үндсэн чиглэлээр мэдлэгээ дээшлүүлснээс гадна Нидерландын Арнхем, Зволле, Роттердам хот дахь Эвидес болон Витенс усны



байгууллагад зочилж, технологийн шинэчлэлүүдтэй танилцлаа. Түүнчлэн сурсан мэдсэнээ бусдадаа хуваалцан байгууллагынхаа үйл ажиллагаанд нэвтрүүлж, Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуургын системийг сайжруулахаар төлөвлөгөө гарган танилцуулсан юм.

вэбинарыг зохион байгуулж буй бөгөөд 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр "Ус хангамж, ариутгах татуургын салбарын зохицуулалт, хэрэглэгчийг хамгаалах бодлого" сэдэвт вэбинарт Молдовын Эрчим хүчний зохицуулалтын үндэсний агентлаг (ANRE)-ийн төлөөллүүд оролцож, үнэтэй туршлага, мэдлэгээ хуваалцлаа.

Товчхон:

Зардал нөхөх дэд үйл ажиллагааны хүрээнд Үндэсний Статистикийн Хороотой хамтран "Ус худалдан авах чадварын судалгаа"-г боловсруулж, үр дүнг нь 2024 оны 7 дугаар сард усны салбарын гол оролцогч талуудад танилцуулсан. Энэ ажлын хүрээнд усны нийгмийн бодлогын олон улсын шилдэг туршлагаас судлах цуврал

Монголын Мянганы сорилтын сангийн Гүйцэтгэх захирал
Э.Энхгэрэл: Усны Компакт бол сүүлийн 30 жилд усны салбарт оруулж буй хамгийн том хөрөнгө оруулалт

Түрүүч нь 1-р нүүрт

Усны Комплектыг уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг ухаалаг хөрөнгө оруулалт хэмээн АНУ-ын Мянганы сорилтын корпорацаас онцолж, тус улсын Олон улс, стратеги судлалын хүрээлэнгээс Вашингтон хотноо зохион байгуулсан дэд бүтцийн хөрөнгө оруулалтын шинэ жишгийн талаарх хэлэлцүүлэг, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг КОП29 арга хэмжээнд Усны Комплектыг онцлон, ач холбогдлыг олон улсад танилцууллаа.

Ус хангамжийг сайжруулах бүтээн байгуулалтын ажлыг нийгэмд ээлтэй, олон нийтийн эрх ашигт нийцтэй байхад чиглэсэн усны нийгмийн бодлогын асуудлыг Монгол Улсын Засгийн Газрын Мөрийн хөтөлбөрт тусгалаа.

Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд ус хангамжийн шинэ эх үүсвэрүүдийг байгуулахын зэрэгцээ хаягдал усаа дахин ашиглах замаар газрын доорх усаа хэмнэх боломжийг бүрдүүлж, орчин үеийн дэвшилтэт технологиудыг эх орондоо анх удаа нэвтрүүлж, олон улсын түвшинд мега төсөл хэрэгжүүлэх үндэсний чадавх бүрдэж байна.



2024.12.24

Монголын Мянганы сорилтын сангийн Удирдах зөвлөлийн хурлаар Усны Комплектын хүрээнд хэрэгжүүлж буй төслүүдийн явц, тулгамдаж буй асуудал, учирч болзошгүй эрсдэл, түүнийг бууруулах арга хэмжээний талаар болон бусад асуудлыг хэлэлцэж, холбогдох шийдвэрүүдийг гаргалаа.

Монголын Мянганы сорилтын сангийн Дотоод аудитын газрын захирал

Б.Батбаяр: Монголын Мянганы сорилтын сангийн бүх үйл ажиллагааны тоглоомын дүрэм тодорхой, ойлгомжтой учир авлигаас ангид байдаг

Түрүүч нь 1-р нүүрт

2020 оны 1 дүгээр сард Байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө гаргаж, эрсдэлийн бүртгэл хөтөлж эхэлсэн бөгөөд түүнийгээ тогтмол шинэчилж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч ажилладаг. Мөн АНУ-ын МСК-тай хамтран Залилан, авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж байгаа. Бид ажилтнуудаа байгууллагын соёл, бэлгийн дарамт, авлига, залилангийн эсрэг сургалтуудыг тодорхой давтамжтайгаар зохион байгуулж, аливаа зүй бус, авлигын

шинжтэй үйлдэл ажиглагдвал нэн даруй мэдээлэх утас, хаяг бүхий хуудас ажлын байранд энд тэндгүй наалттай байгаа. Бид зөвхөн байгууллагынхаа хүрээнд төдийгүй гэрээт компаниуддаа мөн адил ийм шаардлага тавьж, биелэлтэд нь хяналт тавьж, сар тутам тайланг нь авдаг. Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэхэд олон улсын "Birches Group" мэргэжлийн туслалцаа үзүүлдэг. Ингэхдээ гүйцэтгэлийн үнэлгээний 360 градусын аргыг хэрэглэж байна.



Эх сурвалж: itolm.mn

Монголын Мянганы сорилтын сангийн Байгаль орчны асуудал хариуцсан захирал

Ц.Дашзэвэг: Газрын гүнд нь үлдээж байгаа ус "экосистемийн үйлчилгээ"-ний хувьд Туул голын сав газарт маш чухал



Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллах үед нийслэлийн хэмжээнд жилд 18 сая хүртэл шоо метр цэвэр усны нөөцийг хэмнэнэ. Өөрөөр хэлбэл энэ төслийн тусламжтайгаар Улаанбаатар хотын орон сууцанд амьдарч буй нийт айл өрхийн жилийн хэрэглээний 50 хувьтай тэнцэх хэмжээний газрын доорх усыг хэмнэх боломж бүрдэнэ. Нөгөөтэйгүүр жил бүр газрын гүнд нь үлдээж байгаа ус нь экосистемийн үйлчилгээний хувьд Туул голын сав газарт маш чухал нөлөөтэй. Туул голын бүрэн бүтэн байдлыг хангахад чухал нөлөө үзүүлнэ.

Сонирхолтой тоо баримт:

Бүтээн байгуулалт эхэлснээс хойш:

- 6096** Хүнийг ажлын байраар хангасан
- 90%** Монголчууд
- 744** Эмэгтэй /12%/
- 1/3** СХД, ХУД, БГД-ийн иргэд
- 58.1** ЖДҮ-ээс худалдан авсан бараа үйлчилгээ тэрбум.төг


Монгол-Америкийн парламентын бүлгийн гишүүдтэй уулзав

Монголын Мянганы сорилтын сан, АНУ-ын Мянганы сорилтын корпорацын төлөөлөл Улсын Их Хурал дахь Монгол-Америкийн парламентын бүлгийн гишүүдтэй уулзаж, Усны Комплектаар хэрэгжүүлж буй Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын талаар танилцууллаа. Уулзалтын үеэр бүлгийн гишүүд Улаанбаатар хотын амин чухал усны асуудлыг цогцоор

шийдвэрлэхээс гадна хотыг баруун тийш тэлж, төвлөрлийг сааруулах замаар нийслэлд тулгамдаж буй олон асуудлыг шийдвэрлэхэд үнэтэй хувь нэмэр оруулах чухал төсөл хэмээн Усны Комплектын ач холбогдлыг онцлоод, төслийг цаг хугацаанд нь, амжилттай хэрэгжүүлэхэд бүлгийн зүгээс дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллахад бэлэн байгаагаа илэрхийллээ.



Компакт гэрээ хэрэгжиж дуусахад



үлдлээ